# ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЗААВАРЧИЛГАА

## *I.Мэдээлэл оруулах дараалал*

1. *МХБ-ийн веб сайтад байршсан цахим мэдээллийн санд хандах*
2. *Мэдээлэл оруулах санд нэвтрэх*
3. *Маягтын дагуу мэдээллийг оруулах*
4. *Мэдээлэл оруулах бичиглэлийн хэлбэр*
5. *Хавсралт материал оруулах*
6. *Нэг төрлийн хэд хэдэн мэдээлэл оруулах*
7. *Мэдээллийн төрлийг нэмж оруулах*
8. *Бусад мэдээлэл*
9. *Мэдээллийг санд байршуулах*
10. *Мэдээлэлийн санд нэвтрэх нууц үгийг солих*
11. *Веб дээрхи мэдээллийн маягтын харагдац*

### *1.МХБ-ийн веб сайтад байршсан цахим мэдээллийн санд хандах*

Компанийн үнэт цаас хариуцсан мэргэжилтэн нь МХБ-ийн веб сайт дахь мэдээллийн санд http://www.mse.mn//bvrtgel/admin хаягаар хандан мэдээлэл оруулах санд хандах боломжтой юм.

*/Зураг №1/*




### *2. Мэдээлэл оруулах санд нэвтрэх.*

http://www.mse.mn//bvrtgel/admin хаяг руу хандаж “Админы нэр” гэсэн хэсэгт гурван ширхэг латин тэмдэгтээс бүрдсэн компанийн симболыг, “Нууц үг” гэсэн хэсэгт МХБ-ээс өгсөн нууц үгийг бичиж “Нэвтрэх” товчыг дарж мэдээлэл оруулах санд нэвтрэх ба холбогдох нууц үгийг буруу хийсэн тохиолдолд системээс алдаа заах болно /зураг №2/

*/зураг №2/*




***3.Маягтын дагуу мэдээллийг оруулах.***

Компанийн үнэт цаас хариуцсан мэргэжилтэн мэдээллийн санд амжилттай нэвтэрсэнээр мэдээлэл байршуулах 12 төрлийн маягтууд гарч ирнэ. /Зураг №3/

*/Зураг №3/*




Мэдээлэл байршуулах маягтын төрлүүдээс мэдээлэл оруулах маягтаа сонгож, гарч ирэх самбарын дээд хэсэгт байрлах “Шинээр нэмэх” гэсэн сонголтыг дарснаар мэдээлэл оруулах маягт гарч ирэх юм. “ Харах “ “ Засах”, ” Устгах ” сонголтуудаар шаардлагатай үйлдлийг гүйцэтгэнэ. /Зураг №4, №5, №6/

*/Зураг №4/*




***Компанийн ерөнхий мэдээлэл***

*/Зураг №5/*



## *Санхүүгийн тайлангийн мэдээлэл*

*/Зураг №6/*

### Санхүүгийн тайлангийн мэдээ нэмэх

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1. | Сонго Сонго -р улиралын санхүүгийн тайлан | | /төгрөгөөр/ | |
| 2. | **Санхүүгийн тайлан** | | Эхний үлдэгдэл ... | Эцсийн үлдэгдэл ... |
| 3. | **Санхүүгийн үзүүлэлтүүд** | | Санхүүгийн тайлангийн хуулбар Browse... | |
| | Нийт хөрөнгө | | | |
| | Өр төлбөрийн нийт дүн | | | |
| | Эзэмшигчдийн өмчийн дүн | | | |
| | Нийт хувьцааны тоо ширхэг | | | |
| 4. | **Орлого үр дүнгийн тайлангийн үзүүлэлт** | | | |
| | Нийт борлуулалтын орлого | | | |
| | Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | | | |
| | Нийт ашиг | | | |
| | Цэвэр ашиг | | | |
| | Нэгдсэн ашиг | Энгийн | | |
| | | Давуу эрхийн | | |
| | Нэгж хувьцааны дансны үнэ | | | |
| | Хувьцааны хаалтын ханш | | | |
| 5. | **Санхүүгийн харьцаанууд** | 1.Нийт хөрөнгийн өгөөж /ROA/ | | |
| | | 2.Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/ | | |
| | | 3.Нийт хөрөнгийн эргэц /ROTA/ | | |
| | | 4.Нэгж хувьцааны өгөөж /EPS/ | | |
| | | 5.Үнэ ашгийн харьцаа | | |
| 6. | **Аудит хийсэн байгууллагын нэр** | | | |
| 7. | **Аудитын дүгнэлт хийсэн огноо** | | ... | |
| 8. | **Аудиторын дүгнэлт** | | Дүгнэлтийн хуулбар Browse... | |

**Хадгалах** Буцах

### *4.Мэдээлэл оруулах бичиглэлийн хэлбэр*

Мэдээллийн маягтад оруулах текстэн утгыг Монгол үсгийн фондоор бичих бөгөөд тоон утга оруулах нүдэнд зөвхөн тоон цифр оруулна.

Жич: Монгол үсгээр мэдээлэл оруулахдаа Монгол фондоор оруулах бөгөөд зөвхөн “Windows XP” /зураг №7/ үйлдлийн системийн фондоор мэдээллийг оруулна. Хэрэв “Monkey” программын фондыг ашиглабал веб сайтад үсгийн фондыг танидахгүй.

*/Зураг №7/*




### *5.Хавсралт материал оруулах*

Мөн мэдээллийн санд хавсарган ирүүлэх шаардлагатай материалыг компанийн үнэт цаас хариуцсан мэргэжилтэн сканердан файл хэлбэрээр хадгална. /.pdf .doc өргөтгэлтэй/

Хадгалсан файлыг маягтын “ browse ” сонголтон дээр дарж мэдээллийн санд байршуулна.

*/Зураг №10/*



*/Зураг №11/*




## ***6.Нэг төрлийн хэд хэдэн мэдээлэл оруулах***

Мэдээллийн санд байрших нэг төрлийн хэд хэдэн мэдээлэл оруулах тохиолдолд “нэмэх” гэсэн сонголтыг дарж нэмэлт утгыг оруулах талбарыг бий болгоно. /Зураг №12/ Хэрэв нэмэлт талбарыг хэрэгцээгүй гэж үзсэн тохиолдолд “хасах” гэсэн сонголтыг дарж талбарыг арилгах боломжтой. /Зураг №13/

*/Зураг №12/*




*/Зураг №13/*



## *7.Мэдээллийн төрлийг нэмж оруулах*

Зарим маягтад мэдээллийн төрлийг нэмж оруулахдаа сонголтыг чагтлах байдлаар нэмэлт мэдээллийг оруулж болно. /Зураг №14, Зураг №15/

*/Зураг №14/*




*/Зураг №15/*




## *8.Бусад мэдээлэл*

“ Компанийн үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээлэл” гэсэн маягтанд компани нь өөрийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, удирдлага менежмент, хөрөнгө оруулалт болон бусад олон нийтэд хүргэх шаардлагатай бүх төрлийн мэдээллийг оруулна.

## *9.Мэдээллийг санд байршуулах*

ХК-ийн үнэт цаас хариуцсан ажилтан мэдээллийг маягтын дагуу оруулж дууссаны дараа маягтын доод хэсэгт байрлах “Хадгалах” сонголтыг дарснаар уг мэдээлэл нь МХБ-ийн web-ийн мэдээллийн санд бүртгэгдэж МХБ-ийн компани хариуцсан мэрэгжилтэнд мэдээлэл ирсэн тухай mail ирнэ. Энэ хэсэгт бүртгэгдсэн мэдээллийг засах, өөрчлөх боломжтой байна. /Зураг №16/

*/Зураг №16/*




Хэрэв маягтын ямар нэгэн утга буруу, эсвэл дутуу үед алдааны шалтгааныг заасан цонх дэлгэцэн дээр гарч ирнэ./Зураг №17/

*/Зураг №17/*




Мэдээлэл ирсний дараа Бүртгэлийн албаны компани хариуцсан мэргэжилтэн мэдээллийг хянаж, "Нийтлэх" гэсэн сонголтыг идэвхижүүлснээр мэдээлэл олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдэнэ.

### *10.Мэдээлэлийн санд нэвтрэх нууц үгийг солих*

Шаардлагатай тохиолдолд компанийн үнэт цаас хариуцсан мэргэжилтэн өөрийн нэвтрэх нууц үгийг сольж болно. Мэдээллийн сангийн үндсэн хэсгийн зүүн дээд талд байрлах "Нууц үгээ солих" гэсэн сонголтыг дарж нууц кодыг өөрчлөх боломжтой. /Зураг №18, Зураг №19/

*/Зураг №18/*




*/Зураг №19/*




### *11.Веб дээрхи мэдээллийн маягтын харагдац*

МХБ-ийн биржийн веб сайт [http://www.mse.mn/](http://www.mse.mn/) руу нэвтэрч “Компаниуд” гэсэн цэсийг ачаалж “Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалт”, “Бүртгэлтэй компанийн жагсаалт” гэсэн сонголт дотроос тухайн компанийн нэрийг сонгон дарснаар мэдээллийн цахим маягтууд гарч ирнэ. /Зураг №20, Зураг №21, Зураг №22, Зураг №23/

*/Зураг №20/*



*/Зураг №21/*

**АРИЛЖАА**

Хураангуй » Файлаар авах /XLS/
Дэлгэрэнгүй » Файлаар авах /XLS/
Долоо хоногийн арилжааны тойм

**ШУУРХАЙ МЭДЭЭ**

[2010-02-05]
**"Өгөөж Сүмбэр" ХК хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаа зарлажээ.**

**БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААСНЫ ЖАГСААЛТ**

**МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам-р тавигдсан шалгуур, шаардлагыг хангасан буюу хууль, дүрэм журам гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт хангалттай компанийн жагсаалт.** /2009 оны 06-р сарын 01-ний байдлаар/

| № | Код | Симбол | Хувьцаат компанийн нэр | Харъяалал |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | UYN | "Монгол савхи" ХК | Улаанбаатар |
| 2 | 3 | ULN | "Улаанбаатар зочид буудал" ХК | Улаанбаатар |
| 3 | 5 | TLG | "Тулга" ХК | Улаанбаатар |
| 4 | 7 | UBH | "Улаанбаатар хивс" ХК | Улаанбаатар |
| 5 | 8 | HRD | "Хүрд" ХК | Улаанбаатар |

Гарч ирсэн мэдээллийн төрлүүдийн нэрэн дээр эсвэл баруун талд нь байх "+" гэсэн сонголтон дээр дарахад тухайн маягтад багтсан мэдээллүүд гарч ирнэ.

*/Зураг №22/*

- Компанийн ерөнхий мэдээлэл +
- Санхүүгийн тайлангийн мэдээ +
- Олон нийтэд санал болгосон үнэт цаас +
- ТУЗ болон ХШЗ-ийн гишүүдийн мэдээлэл +
- Компанийн удирдлагын талаарх мэдээлэл +
- Хувьцааны 5% дээш багц эзэмшигч +
- Их хэмжээний хэлцэл хийсэн тухай эсэх +
- Бусдад барьцаа баталгаа гаргасан тухай эсэх +
- Томоохон ээлдүүлэгчид, харилцагчдын мэдээлэл +
- Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдээ +
- Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр +

*/Зураг №23/*

Томоохон ээлдүүлэгчид, харилцагчдын мэдээлэл +

Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдээ +

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1. | **Хувь нийлүүлэгчдийн хурал** | | Ээлжит | |
| 2. | **ХНХ хуралдах хугацаа** | | 15 | |
| 3. | **Бүртгэх өдөр** | | 2009-12-22 | |
| 4. | **Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах өдөр** | | 2009-12-17 | |
| | Зарлуулсан эх сурвалж /он, сар, өдөр, дугаар/ | | Өдрийн сонин | |
| 5. | **Хуралдах газрын хаяг** | | БЗД 51 байр | |
| 6. | **Хурлаар хэлэлцэх асуудлууд** | | 1.<br>2. | |
| 7. | **Шийдвэр** | Гаргасан этгээд | ТУЗ | |
| | | Огноо, дугаар | | № 152 |
| 8. | **Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн** | | Рйжуцхфцж | |
| 9. | **Холбоо барих утас** | | 991155252 | |

## *II.Үр дүн*

- *Бүртгэлтэй ХК-иудад хуулиар хүлээсэн үүргээ бүрэн, шуурхай хэрэгжүүлэх боломж нэмэгдэнэ*

- *Бүртгэлтэй ХК-иудтай холбоотой олон нийтэд хүргэх мэдээллийн төрөл нэмэгдэнэ*
- *Мэдээллийн ил тод, шуурхай, үнэн зөв байдал хангагдана*
- *Бүртгэлтэй ХК-иудтай холбоотой мэдээллийн нэгдсэн бааз бүрдэнэ*
- *Иргэд хөрөнгө оруулагчдад үнэн зөв мэдээллийг шуурхай хүлээн авах боломж нэмэгдэнэ .*
- *Техник ажиллагаа багасна.*
- *Хариуцлагын тогтолцоо боловсронгуй болоход эерэг үр дүн үзүүлнэ.*

**БҮРТГЭЛИЙН АЛБА**